

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл

Монгол Улсын ОУИТБС-ын ээлжит 6 дугаар хуралдаан 2010 оны 3 дугаар сарын 5- ны өдрийн 12 цаг 45 минутад Төрийн ордны “Г” танхимд болов.

Хуралдаанд Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригт болон зөвлөлийн гишүүд Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, Авилгатай тэмцэх газрын дарга Ч.Сангарагчаа, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Эрдэнэт Үйлдвэр ХХК-ийн ерөнхий менежер И.Идэш, Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК-ийн ажилтан У.Баярхүү, Арева монгол ХХК-ийн ажилтан Д.Луузан, “Нээлттэй нийгэм форум”-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, менежер Н.Дорждарь, “Ил тод” сангийн зохицуулагч Д.Цэрэнжав, Монголын ажил олгогч эздийн холбооны ерөнхийлөгч Л.Нямсамбуу, “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор нар оролцов.

Мөн хуралдаанд, Засгийн газрын ахлах референт, ОУИТБС-ын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумьяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Баттөр, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга Д.Мягмардаш, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү, Татварын ерөнхий газрын Тусгай хяналтын тасгийн дарга Я.Пүрвээ, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, мэргэжилтэн Т.Хүрэлчимэг, “Далай ван Аудит” ХХК-ийн ерөнхий захирал, аудитор Ц.Жигдэн нар урилгаар оролцлоо.

Хуралдааныг Үндэсний зөвлөлийн гишүүн, Сангийн сайд С.Баярцогт нээж хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

С.Баярцогт: Та бүхний амар амгаланг айлтгая. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын өнөөдрийн хуралдаанаар дараахь асуудлуудыг хэлэлцэнэ. Хуралдаанаар хэлэлцэх асуудлууд:

1. Их Британийн Коффеи Интернейшнл Девелопмент компани, Монгол Улсын Далайван аудитын компаниудын хамтарсан багаас гаргасан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Баталгаажуулалтын тайлан. Далайван Аудитын компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн танилцуулна.

2. 2007 оны нэгдсэн аудитын тайлангаар нотлогдсон 775 сая төгрөгийн зөрүүг тодруулсан байдал, цаашид авах арга хэмжээний талаар Сангийн яамны танилцуулга. Танилцуулгыг Сангийн сайд С.Баярцогт хийнэ.

3. Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2010 оны төлөвлөгөөний төсөл. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор танилцуулна.

4. Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн аудитын тайлангийн зардлыг 2009 оны улсын төсвөөс санхүүжүүлэхээр Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгах болон 2011

оны улсын төсөвт тусгах саналын танилцуулга. Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригт танилцуулна.

5. Монгол Улсын ОУИТБС-ын 2008 оны нэгдсэн аудитын тайлангийн явцын тухай. ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон танилцуулга хийнэ.

За ингээд эхний асуудалдаа оръё.

1. **ХЭЛЭЛЦСЭН** нь: Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Баталгаажуулалтын тайлангийн танилцуулгыг Далайван Аудит компанийн ерөнхий захирал Ц. Жигдэн танилцуулна.

Д.Зоригт сайд хуралдаанд орж ирэв.

Ц.Жигдэн: За бүхний энэ өдрийн амар амгаланг эрье. Их Британийн Коффеи Интернейшнл Девелопмент компани манай Далайван аудитын компанитай хамтран Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Баталгаажуулалтын тайланг гаргасан билээ. Энэ хурал дээр дээрх тайлангийн талаар би танилцуулах үүрэг хүлээсэн юм. /Танилцуулгыг хавсаргав./

Сайд С.Баярцогт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Баттөрийг өөрийн оронд хуралдаанд суулгахаар дуудан ирүүлж, хуралдааны даргаас чөлөө авч явав.

Д.Зоригт: За танилцуулга хийсэн Жигдэн гуайд баярлалаа. Гишүүдэд асууж тодруулах зүйл байна уу?

П.Эрдэнэжаргал: Надад нэг асуулт байна. Жигдэн гуай өөрийнхөө саналыг хэлээч. Эхний тайлан бол их боломжийн, нааштай сайн болсон гэж бодож байна. Харин Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын саналыг тусгаж 5 асуудлаар тэнцээгүй гэсэн засварласан тайланг гаргахдаа бидний зүгээс, монголын оролцогч талуудаас тодруулга, саналыг авалгүйгээр, зөвлөлгүйгээр өөрчилсөн байсан. Ерөнхийдөө би санал нийлж байгаа боловч үнэлгээ хийсэн хүмүүс өөрсдийн үзсэн харсан хүрээндээ л тайландаа эргүүлж засвар хийсэн байсан. Баталгаажуулагч нарт ийм эрх байгаа юу? Энэ талаар та юу гэж бодож байна.

Ц.Жигдэн: Зөрүү дүнгийн талаар тодорхой хариулт өгөх хүн олдоогүй. Энэ асуудлыг учрыг олох асуудал эзэнгүйдээд байгаа юм байна гэж ойлгосон. Баталгаажуулагчдын хувьд дахин эрэн сурвалжлах цаг, нөхцөл боломж нь ч байгаагүй.

Д.Зоригт: Өөр асуулт байна уу? Байхгүй байна. Тэгвэл санал байна уу?

П.Эрдэнэжаргал: Орчуулгын талаар надад нэг санал байна. “Хэрэгжүүлэхэд ойлтсон орон” гэсэн нь олон нийтэд буруу ойлголт төрүүлэхээр орчуулга болжээ. Бид уул нь хэрэгжүүлээд явж байгаа шүү дээ. Үүнийг “хэрэгжүүлэгч орны шалгуурыг хангахад ойлтсон” гэж орчуулах нь зүйтэй.

Д.Зоригт: Англиар нь юу гэж байна.

П.Эрдэнэжаргал: Close to complains гэж байгаа юм.

Д.Зоригт: Тэгвэл хэрэгжүүлэхэд биш “шалгуур хангахад ойртсон” гэж орчуулмаар юм байна шүү дээ. Орчуулга дээрээ анхаарахгүй бол буруу зөрүү ойлголт төрүүлнэ. Манайх чинь хэрэгжүүлж байгаа орон байлгүй яах вэ. Мөнгө төгрөг зарцуулаад 2, 3 тайлан гаргачихсан, үндэсний зөвлөл, ажлын хэсгээ байгуулчихсан үйл ажиллагаа нь жигдэрчихсэн.

За өөр санал байхгүй бол шийдвэрийн төсөл рүүгээ оръё. Та бүхэнд тараасан байгаа, үүн дээр санал байна уу?

П.Эрдэнэжаргал: Баталгаажуулалтын тайлантайгаа хамт цаашдын төлөвлөгөө, стратегиа олон нийтэд мэдээлэх үү, үгүй юу гэсэн асуулт байна.

Н.Дорждарь: Надад нэг санал байна. Баталгаажуулагч нар нэлээд олон санал зөвлөмж өгсөн байгаа. Тэгэхээр үүний дагуу төлөвлөгөө гаргаад хэрхэн хэрэгжүүлэх талаараа төлөвлөвөл яасан юм бэ?

Д.Зоригт: Шийдвэртээ цаашид авах арга хэмжээнээсээ оруулъя гэж байгаа юм байна. Тэгэхээр зөвлөмж тус бүрээр авах арга хэмжээгээ оруулах хэрэгтэй юм байна.

Л.Нямсамбуу: Энэ баталгаажилтын тайлан гэж маш сайн тайлан гардаг юм байна. Тэгэхээр энэ зөвлөмжүүдийг 2010 оны төлөвлөгөөнд дотроо суулгаж хэрэгжүүлэх ёстой байх, 2010 оны төлөвлөгөөний төсөлд бараг бүгд суусан байна лээ. Харин зарим нэг хэсгийг харж байхад нэгтгэн бөөнөөр нь оруулсан байна лээ.

Д.Зоригт: За тэгвэл шийдвэртээ энэ талаар нэмж оруулъя.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Их Британийн Коффеи Интернейшнл Девелопмент компани, Монгол Улсын Далайван аудитын компаниудын хамтарсан багаас гаргасан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Баталгаажуулалтын тайланг хэлэлцээд дэмжиж батлахаар тогтов.

2. Энэхүү баталгаажуулалтын тайланг Монгол Улсын ОУИТБС-ын Үндэсний Зөвлөл дэмжиж баталсан тухай мэдээ болон тус тайланг Олон улсын ОУИТБС-ын Удирдах хороонд хүргүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

3. Баталгаажуулалтын тайланг нийтэд ил тод болгох, хэвлэн нийтлүүлэх арга хэмжээ авахыг Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор үүрэг болгов.

4. Тайлангийн дүн, цаашдын зорилтын талаар Засгийн газрын хэвлэл мэдээллийн албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг ОУИТБС-ын Ажлын албанд даалгав.

5. ОУИТБС-ын баталгаажуулалтын тайлангийн талаар баталгаажуулагчдын зөвлөмжийг ОУИТБС-ын 2010 оны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарт үүрэг болгов.

Дээрх шийдвэрийг бүгд зөвшөөрөв.

Н.Дорждарь: Надад нэг мэдээллийн чанартай зүйл байна. Бид нар 2010 оны 3 дугаар сарын 9-ний дотор баталгаажуулалтын ажлыг дуусгасан байх ёстой. Дууссан гэдэг тодорхойлолтыг авахын тулд 3 үзүүлэлтийг хангасан байх ёстой байгаа. Нэгт, Үндэсний зөвлөлийн хуралдаанаар баталгаажуулалтын тайлангаа хэлэлцэж баталсан байх ёстой. Хоёрт, үүнийгээ хэвлэл, мэдээллээр олон нийтэд мэдэгдэх ёстой. Гуравт, баталгаажуулагчид төлбөрийг төлж дуусгах ёстой. Тэгэхээр бид хуралдаанаа хийчихлээ, хэвлэл мэдээллээр мэдэгдэнэ. Харин тэр төлбөрийг нь хийсэн үү?

Ш.Цолмон: Төлбөрийн үлдэгдэл 20 хувийг баталгаажуулалтын тайланг Үндэсний зөвлөлөөр баталсны дараа шилжүүлэхээр гэрээнд заасан. Тэгэхээр манай дансанд мөнгө нь байгаа. Энэ хуралдааны дараа шилжүүлэг бэлтгэгдэж холбогдох гарын үсгүүд нь зурагдаж шилжүүлэг хийгдэнэ. Гэхдээ яг 3 дугаар сарын 9-ний дотор техникийн шалтгаануудын улмаас төлбөр багтаж хийгдэж амжихгүй байж магадгүй гэдгээ бид Олон улсын нарийн бичгийн дарга нарын газартай ярьж тохирсон байгаа.

П.Эрдэнэжаргал-Эдгээрийг Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх хэрэгтэй.

Д.Зоригт: За энэ асуудлаа дуусгаж, дараагийн асуудалдаа орьё.

II. **ХЭЛЭЛЦСЭН** нь: 2007 оны нэгдсэн аудитын тайлангаар нотлогдсон 775 сая төгрөгийн зөрүүг тодруулсан байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Сангийн яамны танилцуулга. Уг танилцуулгыг Сангийн сайд Ц.Баярцогт хийх байсан боловч ажил гарсан тул орлож тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Баттөр хийнэ гэж Д.Зоригт хэлэв.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Баттөр 2007 оны нэгдсэн аудитын тайлангаар нотлогдсон 775 сая төгрөгийн зөрүүг тодруулсан байдал, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Сангийн яамны танилцуулгыг хийв. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За баярлалаа, Баттөр даргад. Энэ танилцуулгатай холбогдуулж асуух зүйл байна уу?

Л.Нямсамбуу: Компаниуд татварт тайлангаа өгөхдөө аудитаар баталгаажуулж өгдөг биз дээ. Тэгээд ОУИТБС-ын тайлан гаргахдаа бас энэ тайлангаасаа авч байгаа биз дээ. Тэгэхээр хаана нь зөрүү гараад байна вэ?. Хэн нь худлаа тайлагнаж байна гэж үзээд байна?

Д.Мягмардаш: Энэ тайлан чинь бас яг санхүүгийн тайлан биш юм. Батлагдсан маягтаар авдаг өөр тайлан.

Э.Сумъяа: Нэг тодруулга хийе. Сангийн яам болохоор олборлох үйлдвэрлэл эрхлэгчдээс авсан татвар, төлбөр зэрэг материаллаг орлого тайлагнадаг бол, компаниуд улс, орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр зэрэг материаллаг төлбөрөө бие биеээс хараат бус байдлаар тайлагнаж, түүнд олон улсын эрх бүхий аудитын байгууллага тулгалт хийж тайлан гаргаж байгаа механизм юм.

Л.Нямсамбуу: Харин тийм. Тэгээд хэнийг нь буруу гэж хардах вэ. Миний бодлоор эхлээд өөрсдийнхөө аргачлалыг сайжруулж, тайлагнах үйл явцыг тодорхой стандарттай болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол олон санаа агуулсан тайлангууд гараад зөрөөд байгаа юм.

Ц.Жигдэн: Энэ асуудалтай холбогдуулан би мэргэжлийн аудитор хүний хувьд нэг саналаа хэлээдэхье. Компаниуд 3 дугаар сарын 30-ны дотор ОУИТБС-ын тайлангаа маягт 1-ээр ирүүлэх ёстой. Харин компанийн санхүүгийн тайлан бол 2 дугаар сарын 15 гэхэд л татварын албанд өгдөг. ОУИТБС-ын тайлан бол статистик тайлан гэсэн үг. Санхүүгийн тайланг аудитладаг. Харин санаачилгын тайланг аудитладаггүй, нэгдсэн тайлантайгаа уялдуулахгүй бол хоорондоо холбоогүй ийм л асуудал үүсээд байгаа юм. ОУИТБС болохоор 200.0 сая сая гээд хязгаарлалт тогтоосон байгаа, Уг нь 50.0 саяас дээш заавал аудит хийгдэнэ, харин доош бол сайн дураар аудит хийлгэдэг. Хийж байгаа хүн санаагүй, санаатай алдаа хийж болно. Аудит бол нотлох баримт л цуглуулдаг байгууллага.

Д.Зоригт: Аудитлагдах тайландаа энэ тайланг суулгаж болно биз дээ. 50 саяас дээш компаниуд чинь тэртээ тэргүй л аудитлагдаж байгаа биз дээ. Тэгэхээр тэр тайлан дотор нь л энэ тайланг оруулаад өгчихвөл болох юм биш үү. Тэгээд буруу, дутуу тайлагнавал аудитын хуулиараа хариуцлага хүлээдэг байвал зүгээр юм гэж бодож байна.

Д.Мягмардаш-Санаачилгын зарчим өөр. Төрийн захиргааны байгууллагын санхүүгийн тайланг аудитлах үед энэ тайланг гаргаж болох юм уу.

Ш.Цолмон: Ер нь маягтан дээрээ бол аудитлагдсан тайлангийн дүнтэй тохирч байна гэж заасан байдаг. Харин бодит байдал дээрээ материаллаг төлбөр бөгөөд тайлан мөнгөн суурьтай, аккруэл суурьтай гараад тэр нь замд яваа мөнгө, өглөг, авлага гэх мэтээр зөрүү гарчихдаг юм шиг байгаа юм.

Д.Зоригт Ерөнхий сайд дуудлаа гээд гарч явав.

Ц.Жигдэн: Олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд тайлангаа 3 дугаар сарын 1-н гэхэд Татварын ерөнхий газарт өгдөг, тэр нь нэгтгэгдээд 4 дүгээр сард Сангийн яаманд очно. Энэ бол статистик тайлан юм. Харин Санхүүгийн тайлан бол 2 дугаар сарын 10-нд гардаг. Санхүүгийн тайлан аудитчлагддаг. Статистик тайлан хойно гарч байгаа юм. Иймд маягт баталсан 2 байгууллага үүнийгээ харж үзэх ёстой юм.

Н.Баярсайхан-Хандив, тусламжийг бүртгэх журам гаргасан гэлээ. Үүнийг тайлбарлаач.

Д.Баттөр-Хандив, тусламжийг бүртгэх журам Сангийн сайдын 2010 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 45 дугаар тушаалаар батлан гаргасан. Нийтээр дагаж мөрдөх журам тул Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна. Энэ журмыг яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага дагаж мөрдөх юм.

Б.Долгор: Тайлангийн цаг хугацааны хувьд уялдуулах боломжтой юу, ажлын албаныхаан.

Ш.Цолмон: Боломжтой. Харин маягтыг сайжруулахын хувьд бид Сангийн яамтай 1 дүгээр сараас эхлэн ажиллаж байгаа. Маягтын хэд хэдэн загваруудыг гаргасан байгаа. Одоо төсвийн тухай хууль өөрчлөгдөнө гэсэн сураг байгаа тул үүнийг хүлээгээд түр зуур харзнаж байна.

Л.Нямсамбуу: Түрүү Зоригт сайдын хэлсэн шиг санхүүгийн тайлантай нь нийлүүлэх бол нөгөө санаачилгын зарчмууд алдагдах байдалд хүргэнэ. Тэгэхээр энэ тайлан бол тусдаа л энэ байдлаараа явж байсан нь дээр. Харин стандарт байх ёстой. Зөрүү гарч байна гэдэг чинь нэг талаараа бас үндсэн зорилго нь биелэгдэж магадгүй.

Б.Долгор: Тэгж нийлүүлнэ гэж хэлээгүй. Харин цаг хугацааны хувьд уялдуулах ёстой гэдэг нь харагдаж байна.

П.Эрдэнэжаргал: Цаг хугацааны хувьд хоцролттой байна гэдэг чинь маш том дутагдалтай байгаа юм. Манай тайлангууд бол бараг л 2 жил хоцорч гарч ирж байгаа шүү дээ. Тэгэхээр 2 жилийн өмнөх юмыг ухаж үзнэ, мэдээлэл нь хоцрогдсон байна гэх мэтээр ач холбогдол муутай болоод байна л даа. Одоо 2008 оны тайлан гарах гэж байна. 2009 оных бас байна. Тэгэхээр давхардуулж хийх үү, яаж энэ тайлан гаргах ажиллагааг 1 жилийн зөрүүтэй болгох вэ?

Ш.Цолмон: 2008 оны тайлангийн ажил одоо эхэлж байна. 2009 оны тайлангийн хувьд 4 дүгээр сард Засгийн газрын тайлан гарна гэж Татварын ерөнхий газраас хэлсэн. Тийм болохоор санхүүжилт нь шийдэгдчихвэл энэ ондоо багтаад гарчих боломжтой. Харин энэ санхүүжилтийн талаар бид энэ хурал дээр ярилцах юм.

Ц.Жигдэн: Тэр 18 үзүүлэлтийн 5 нь биелээгүй байна гэдэг чинь ердөө л энэ шүү дээ. Биднийг шалгуурт ойрсон гэж хэлүүлээд байгаа юм чинь энэ тайлангийн зөрүү, стандартын дагуу баталгаажуулаагүй гэдэг л асуудал шүү дээ. Би Эрнст Янгийнхантай уулзсан л даа. Санхүүгийн тайлангийн нэгтгэл бол үнэхээр тамтай ажил юм байна. Бараг л зодоон цохион хийж байж, улаа эргэтэл явж байж хэдэн тоог нь гаргуулсан гэж байна лээ. Үүнийг эрхзүйн зохицуулалтыг нь тодорхой болгох хэрэгтэй. Аудитын ажил бол үнэтэй цэнэтэй ажил шүү дээ. Тиймээс санхүүжилтийг нь бас шийдэж өгөх хэрэгтэй.

Б.Долгор: За энэ асуудал дээр саналуудыг сонслоо. Өөр санал байна уу? Гарах шийдвэрийн талаар санал хэлэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын 2007 оны нэгдсэн аудитын тайлангаар нотлогдсон 775 сая төгрөгийн зөрүү, түүний шалтгааны талаархи Сангийн яамны дүгнэлтийг Үндэсний Аудитын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран нягтлан шалгаж, тодорхой арга хэмжээ авч дүнг Үндэсний зөвлөлд 2010 оны эхний хагаст багтаан танилцуулахыг Үндэсний аудитын газрын дарга, Үндэсний зөвлөлийн гишүүн Ч. Раднаад зөвлөмж болгож, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Я.Содбаатарт даалгав.

Б.Долгор- За дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал бол 2010 оны төлөвлөгөөний төсөл байгаа.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын саначилгын 2010 оны төлөвлөгөөний төсөл.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор төлөвлөгөөний төслийг танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

Н.Баярсайхан: Надад нэг асуулт байна. 2009 оны төлөвлөгөөний биелэлт ямар байна вэ? Хэрэв биелээгүй зүйлүүд байгаа бол юунаас болж биелээгүй вэ?

Ш.Цолмон: Яг 2009 оны төлөвлөгөө гэж гаргаагүй. Манайх санхүүжилтийн төслийн хугацаа сунгагдсан учир хийгдэх ажлууд маань анхнаасаа энэ санаачилгыг хэрэгжүүлж эхлэхээс баталгаажуулалтд орох хүртэл асуудлууд нэг төлөвлөгөөнд багтсан байсан. Харин энэ төлөвлөгөөн дотроос биелэгдээгүй ажил ер нь байхгүй дээ. Хамгийн сүүлийн ажил нь баталгаажилтын ажил байгаа. Ажлын хэсгийн хурал дээр биелэлтийг нь боломжийн гэж үзсэн байгаа.

П.Эрдэнэжаргал: Төлөвлөгөөний төслийн 1.8-тай холбоотой асуулт байна. Тайлангийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх, харин ажлын албаны санхүүжилтийг одоохондоо гадаадын хандивлагчдаас олох төлөвлөгөөтэй байна гэж ойлгож болох уу?

Б.Долгор: Ер нь тэгж ойлгож болно. Одоо энэ төсөл маань 10 дугаар сард дуусна. Цаашдаа ямар ч байсан энэ байдлыг хадгалаад харин ч өргөжүүлэх төлөвлөгөө байгаа. Тэрнийхээ мөнгийг олох л хэрэгтэй байна. Төсвөөс санхүүжилт авна гэдэг хөөцөлдөлгөөгөө хийгээд л явж байна.

Э.Сумъяа: ОУИТБС-ыг Дэлхийн банкны хандиваар хэрэгжүүлж байгаа бөгөөд баталгаажуулалтын зөвлөмжид өөриймшүүлэх гэсэн зөвлөмж гарсан бөгөөд үүний тулд 2009 оны тайлан гаргах хөндлөнгийн аудитын зардлыг улсын төсвөөс гаргах гэсэн саналыг төлөвлөгөөнд тусгасан байгаа. Энэ асуудлыг энэ асуудлын дараа хэлэлцэнэ. Харин Ажлын алба бол оролцогч 3 талын тэнцвэрийг хангах зорилготой тул улсын төсвөөс биш, гадны санхүүжилтээр үйл ажиллагаа нь явуулбал зохимжтой юм. Ямар ч байсан санхүүжилт хүссэн хүсэлтээ ЕСБХБ-д тавиад төсөв хийгээд өгчихсөн байгаа. Мөн Дэлхийн банкиндаа бас үргэлжлүүлж санхүүжүүлж өгнө үү гэсэн хүсэлт тавихаар төлөвлөж байгаа.

Н.Дорждарь: Сургалтын талаар нэг юм хэлье. Бүсчилсэн сургалтыг бид 3 удаа зохион байгуулсан. Үр дүн гардаггүй юм билээ. Миний бодлоор бүсчилж биш уул уурхайн ашиглалт ихтэй аймгуудад дангаар нь сургалтуудыг зохион байгуулах

хэрэгтэй юм шиг санагдсан. Ер нь компаниуд уруу чиглүүлсэн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Б.Баярсайхан: Би бас Дорждарьтай санал нэг байна. Бүсийн зөвлөлгөөнд салбар зөвлөл, компаниуд хамрагдахаас биш иргэд тэр бүр оролцох боломжгүй санагдсан. Тэгэхээр аймаг тус бүрт нь сургалт хийх нь зөв гэж бодогдож байна. Харилцаа, олон нийтийн арга хэмжээ гэдэг дээр орон нутгийг чадавхижуулах, ялангуяа аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг чадваржуулж, санаачилгын тайланг аймаг, сумаар хийвэл илүү ая холбогдолтой. Мөн иргэний нийгмийн байгууллагуудаар сургалт, сурталчилгаа, хэвлэн нийтлүүлэх гэрээт ажлуудыг хийлгэх хэрэгтэй байна.

Ш.Цолмон-Зөвлөлгөөний арга барилыг арай өөрөөр хийхээр төлөвлөсөн юм.

П.Эрдэнэжаргал-Зохиож байгаа арга хэмжээг бусад үйл ажиллагаатай, тухайлбал, хариуцлагатай уул уурхай, ТАН эвслийн үйл ажиллагаатай холбох зэргээр төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ ажлын алба анхаарч ажиллах нь зүйтэй.

Л.Нямсамбуу-Баталгаажуулалтын тайлангаас эргэж үзэж төлөвлөгөөний төслийн 1,3-т байгаа олон асуудлыг нэгтгэн оруулсныг задалж оруулах, 3, 5 дугаар сар гэж 1 асуудал 2 өөрөөр тусгасныг засах.

Б.Долгор: За та бүгдээс чухал саналуудыг сонслоо. Зөвлөлгөөн сургалт гэснийг бүсийн, аймгийн гэж уян хатан байхаар, саяны саналуудыг анхааралдаа авч төлөвлөгөөндөө тусгая. Тэгэхээр төлөвлөгөөгөө уян хатан байхаар хийх нь зөв гэж бодож байна. Ингээд энэ төлөвлөгөөгөө баталчих уу?

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2010 төлөвлөгөөний төслийг хэлэлцээд хуралдаан дээр Үндэсний зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг тусган батлахаар тогтов.

2. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2010 оны төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгорт даалгав.

Б.Долгор-Хуралдаанаас гарч байгаа шийдвэрээ батлах уу. Бүгд: Тэгье.

Б.Долгор: За дараагийн асуудал руугаа оръё. Төсөвт суулгах асуудлыг танилцуулах Зоригт сайд түр гарсан байна. Иймд алгасаад 5 дахь асуудлаа ярьж байя.

Ү. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2008 оны нэгдсэн аудитын тайлангийн явцын тухай.

Ш.Цолмон 2008 оны нэгдсэн аудитын тайлангийн явцын талаар танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

Э. Сумъяа: Нэг юм хэлье. Ажлын хэсэг дээр ярьж байгаад энэ удаагийн тайланд орох компаниудад нэг талдаа тайлантай компаниуд ч орсон байгаа. Нөгөө талдаа тайлангүй гэсэн үг. Гэхдээ танай компани нэгдсэн тайланд орох нь байна шүү гэсэн бичиг явуулахад 3 компани тайлангаа нэмж ирүүлсэн байгаа. Тэгэхээр өмнөх тайлангийнхаас зөрүү нэмэгдэж магадгүй. Гэхдээ тайлбартай зөрүү гэсэн үг.

Н.Дорждарь: Газрын тосны компаниудаас ганцхан Петрочайнэ л байгаа юм уу? Үлдсэн компаниудыг нь оруулах боломж байхгүй юу?

Ш.Цолмон: Энэ компаниудын нэрсийг Засгийн газраас ирүүлсэн тайланг үндэслэж гаргасан. Харин аудитын компанитай бол энэ компаниудын тоог нэмэгдүүлэх талаар ярьвал мөн үнэ хөлс нэмэгдэх асуудал босч ирэх байх.

Б.Долгор: За тэгвэл тоог нь нэмэх боломжгүй гэж ойлголоо.

П.Эрдэнэжаргал: Жил бүр аудиторгоо солидог нь дэмий юм шиг санагддаг. Тэгэхээр 2 жилээр гэрээ хийж болдоггүй юм уу?

Ш.Цолмон: Бидний сонгон шалгаруулалт бол Дэлхийн банкны журмаар явагддаг. Тэгэхээр тухайн тухайн жилийнхээ л аудиторыг сонгон шалгаруулж байгаа.

Д.Баттөр: Төсвийн хөрөнгөөр сонгон шалгаруулах хуулийн дагуу санхүүжилт шийдэгдээгүй бол тендерийн сонгон шалгаруулалт хийх боломжгүй байдаг. Харин улсын төсөвт 2 жилийн аудитын хөлсийг нь суулгаж өгвөл болно.

Б. Долгор: За та бүхний саналуудыг сонслоо.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны нэгдсэн аудитын тайлан гаргах ажлын явцыг хэлэлцээд тайлан гаргах талаар ОУИТБС-ын ажлын хэсгээс зохион байгуулсан ажлыг зөв зүйтэй гэж дүгнэв.

2. 2008 оны аудитын нэгдсэн тайлангийн явцад хяналт тавин ажиллаж 2010 оны 5 дугаар сарын 31-ний дотор ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор, Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон нарт даалгав.

Б.Долгор-Өөр саналууд байхгүй бол дараагийн асуудалдаа оръё доо.

Ү. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн аудитын тайлангийн зардлыг 2009 оны улсын төсвөөс санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай оруулах болон 2011 оны улсын төсөвт тусгах санал.

Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн аудитын тайлангийн зардлыг 2009 оны улсын төсвөөс санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай оруулах болон 2011 оны улсын төсөвт тусгах саналын тухай Засгийн газрын ахлах референт, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За энэ асуудалтай холбоотой асуулт байна уу?

С.Мэндсайхан: 2011 оны төсөвт тусгах санал ч яах вэ ойлгомжтой. Харин энэ 2010 оны төсвийн тодотголоор гэсэнтэй холбогдуулаад асуулт асууя. Энэ оны төсөвт тодотгол орно гэж яг шийдэгдсэн зүйл байгаа юм уу? Үндэсний зөвлөлөөсөө Засгийн газрын нөөцөөс ч юм уу санхүүжилт шаардлагатай байна гэж хүсэлт тавьбал яасан юм бэ?

Б.Долгор: Ер нь төсөвт тодотгол орох байх гэсэн хүлээлт бол бидэнд байгаа. Засгийн газрын нөөцөөс гаргана гэвэл нөөцөөс урсгал зардлыг санхүүжүүлэхгүй гэсэн хуулиа зөрчих болох юм.

Д.Баттөр: Би С.Мэндсайхан даргатай санал нэг байна. Үндэсний зөвлөлийн хуралдаанаас заавал төсвийн тодотголоор гэж заалгүйгээр Засгийн газарт санхүүжилтийнхээ талаар хүсэлт тавибал шийдвэрлэх боломжтой юм болов уу гэж бодож байна.

Б.Долгор: За үүнийг тэгвэл Засгийн газар хүсэлт тавих гэдгээр оруулъя. Өөр санал байна уу?

П.Эрдэнэжаргал: Урамшууллын хувьд Үндэсний зөвлөлийн гишүүдэд гэдгийгээ хасах саналтай байна. Харин тэр ажлын хэсэг, үнэлгээний хороон дээрээ нэлээн ачаалалтай ажилладаг юм. Ажлын хэсэг, үнэлгээний хорооныхонд урамшуулал өгье.

Б.Долгор: Батлагдах үгүй нь ч мэдэгдээгүй байхад заавал хасч яах вэ. За тэгэхээр өөр санал байхгүй бол өнөөдрийн хуралдаанаа ингээд өндөрлүүлье.

Н.Дорждарь: Цаашдын санхүүжилтийн талаар ярихад аудитын зардлыг Засгийн газар, компани 2 ээлжлээд хариуцдаг байвал ямар вэ? Бусад улс оронд, тухайлбал, Азербайджанд иймэрхүү практик бас байдаг л даа.

Б.Долгор: Үүнийг судлая гэсэн байдлаар үзье. Өөр санал байна уу?

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2009 оны нэгдсэн аудитын тайлан гаргах зардлыг 2010 оны төсвөөс гаргах талаар Засгийн газарт санал оруулахыг Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн С.Баярцогт, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор нарт даалгав.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2011 оны төсвийн саналыг хэлэлцээд Үндэсний зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган улсын төсвийн 2011 оны төсвийн төсөлд тусгуулахаар Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд уламжлахаар тогтов.

Б.Долгор-Гаргаж байгаа шийдвэртэй холбогдуулан өөр санал байна уу. За байхгүй бол хурлаа дүгнэе. Өнөөдрийн хуралдаанаар 5 асуудал хэлэлцлээ. Хуралдаанаас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх тал дээр Ажлын алба сайн ажиллах хэрэгтэй. Хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэхэд Ажлын хэсэг, Үндэсний

зөвлөлийн гишүүдийн ч оролцоо бас хэрэгтэй. Өнөөдрийн хуралдаанаа ингээд өндөрлүүлье. Цаг заваа гарган хуралдаандаа оролцсон та бүхэнд баярлалаа. Олон улсын эмэгтэйчүүдийн баярын мэндийг хүргэе.

Хуралдаан 14 цаг 30 минутанд дуусав.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Долгор

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ОУИТБС-ын Ажлын албаны ажилтан



Т.Хүрэлчимэг